

## *Döftör-i Ćingiz-nāmd* сурвалжийн орчуулга

Б.Аззаяа /МУИС, ГХСС /

Монголчуудын түүхэнд холбогдох олон зүйл сурвалж бичиг харь хэлээр тэмдэглэгдэн үлдсэн нь бий. Тэдгээр сурвалжийн нэг болох *Döftör-i Ćingiz-nāmd*-ийн хувилбар эх түрэг олон хэл аялгуугаар эдүгээ бидэнд уламжлагдан иржээ.

Тэдгээр хувилбар эхийн нэг татар хэл, араб үсгээр бичигдсэн “*Döftör-i Ćingiz-nāmd*” хэмээх сурвалж юм. Уг сурвалж зургаан бөлөг, дөрвөн хувилбартай ажээ. Эдгээрээс гурван хувилбарыг Мажарын эрдэмтэн Maria Ivanics, Mirkasym A.Usmanov нар 2002 онд “*Studia Uralo-Altaica*” цувралын 44 дүгээрт /германаар/ оршил, удиртхалын хамт хэвлүүлжээ<sup>19</sup>. Эрдэмтэд уг сурвалжийг орчуулсангүй, харин галиглан буулгаж сурвалжид гарах зарим үгийн толь хавсаргажээ.

Уг сурвалжийн талаар 1972 онд Казан хотод хэвлэгдсэн “Татарские исторические источники XVII-XVIII вв.” гэх номонд анх дурдсан байна. Энэхүү бүтээл гарахаас өмнө тус сурвалжийн өөр 40 гаруй гар бичмэл хувилбар олоод байсан аж.

Харин шинжлэх ухааны үүднээс хамгийн анх 1934 онд Абдулкадир Инан “*Destan-i nesli Zengiz Han kitabı hakkında 1*” гэсэн бүтээлдээ тухайлан товч өгүүлсэн бөгөөд түүнээс хойш судалгааны тоймтой бүтээл хараахан гараагүй бололтой.

XIX зуун эхэн үеэс уг сурвалжийн талаарх мэдээ түрэг судлалын ертөнцөд хэдийнээ танил болсон бөгөөд XX зууны үед Оросын судлаачид зарим бүлгүүдийг нь орчуулан хэвлүүлсэн ажээ.

Казаний их сургуулийн археогеографикийн шинжилгээний ангийнхан Татарын Ижил мөрөн хийгээд Уралын нуруу, түүний ойр хавийн нутгаар хийсэн судалгааныхаа үр дүнд эл сурвалжийн бүрэн ба бүрэн бус хувилбаруудыг шинээр нэмж олсон байна.

Судлаач Rieu<sup>47</sup>, A.Rahim<sup>48</sup> нар энэхүү сурвалжийг XVII зууны үед бичигдсэн хэмээн таамаглал дэвшүүлсэн нь эдүгээ олон зүйлээр батлагдсаар байна.

Жишээ нь, уг сурвалж XVII зууны 2-р хагаст Татарт болсон улс төр, шашны олон зүйл үйл явдлыг агуулсан байдаг нь дээрх таамаглал үнэн болохыг давхар нуталж байна.

<sup>47</sup> Rieu, Ch.Catalog of the Turkish Manuscripts in the BritishMuseum, London, 1888

<sup>48</sup>Рдхlm, G-Gdziz, G. Tatar ddbiyatitarixi, Kazan, 1925

Бид тус сурвалжийн дээрх эхийг монгол хэлнээ хөрвүүлэн 2006 онд хэвлүүлсэн билээ<sup>49</sup>.

“Ddftdr-i Ćingiz-nāmd” нь олон гар хуулбараар тархсан тул анхны эхээсээ нэлээд зөрүүтэй болсон ажээ.

Үүний нэг нь *Цтемиш Наси* нэрт хүн бичсэн хэмээх хувилбар эх юм. Уг эхийг 1967 онд эрдэмтэн В.П.Юдин Өзбек улсын Шинжлэх ухааны академийн, Дорнодахин судлалын хүрээлэнд хадгалагдаж байсныг судлан 1983 онд өөрийн судалгааны бүтээлээ туурвижээ<sup>50</sup>.

Уг хувилбар эх бидний орчуулан судалсан эхээс нэлээд зөрж байгааг тэмдэглэе.

*“Ddftdr-i Ćingiz-nāmd” сурвалжийн араб үсэг, татар хэлээрх хувилбар эх*

Уг сурвалж Ижил мөрний эхээр нутагладаг, XVI-XVIII зууны үеийн Татаруудын утга зохиолын хэл найруулгаар бичигдсэнээрээ нэн онцлогтой юм.

Хэдийгээр зохиогч нь тодорхой бус ч тухайн үеийн шилдэг боловсролтон, аман үлгэр домог хийгээд эртний сурвалж бичиг, зохиолыг сайтар мэддэг хүн туурвисан нь дээрх бүтээлээс илэрхий байгаа билээ. Өөрөөр хэлбэл, энэхүү домгийн шинжтэй түүхийн зохиолыг бичихдээ түүхийн олон мэдээ сурвалж, ардын аман домог, туульсыг ашигласан нь тодорхой байна.

“Ddftdr-i Ćingiz-nāmd” нь туульсын шинжтэй бөгөөд тухайн үеийн түрэг угсаатны олон аман аялгуу, бичгийн хэлний онцлогийг тусгасан хэд хэдэн бөлгөөс бүрдэж байна. Бүлэг тус бүрийн өгүүлэмж өөрийн гэсэн онцлогтой бөгөөд хэтрүүлэл, ихэсгэл, хүншүүлэл зэрэг уран дүрслэлийн арга, хэрэглүүрийг ашиглаж бичсэн нь уг сурвалжийг баатарлагийн туульстай төсөөтэй болгожээ.

Эхний бүлгийн үйл явдал эрт үеэс аваад Чингис хааны үе буюу XIII зуун хүртэл үргэлжилж байгаа бол, төгсгөлийн 6-р бүлэг нь XVII зууны үеийн үйл явдлыг өгүүлээд өндөрлөж байна. Энэ мэтчилэн бүлэг тус бүр өөр өөр цаг үеийн үйл явдлыг тусгаж байгаагаараа онцлог юм.

Нэгдүгээр бүлэг: *Faṣl-i dāstān-i nōsl-i Jingiz* / Чингисийн язгуурын домгийн хэсэг./

Татарууд исламын шашинд бүрнээ орж олон зууныг туулсан учир энэ сурвалжид их хаадын угсааг дурдахдаа Алладын ариун элч Нухаас эхлэн өгүүлсэн нь исламын ертөнцийнхний түүх бичлэгийн уламжлалтай холбоотой бололтой. Түүнчлэн тэд Алтан Ордны улсыг байгуулж асан түрэг аймгуудын хойчис байсан тул энэ хэсэгт Алтан

<sup>49</sup>Б.Азаяа, “Ddftdr-i Ćingiz-nāmd” сурвалжийн судалгаа, -“CORPUS SCRIPTORUM”, Том.V, УБ., 2006

<sup>50</sup>В.П.Юдин, Орды: Белая, Синяя, Серая, Золотая ..., -Казахстан, Средняя и Центральная Азия вXVI—XVIII вв., Алма-Ата, 1983

Ордны хаадын нэрс дурдагдаж байна. Тухайлбал, Токтога хаан (Тоqтога Нāн نڭاغي ٲوقتا), Өзбег хаан (Цзбег Нāн نڭا و ز بک), Жанибек хаан (Janibdk Нāн نڭا جنبک), Бердибег хаан (Berdibeg Нāн نڭا بک برد) гэх мэт.

Эл бүлэгт Чингис хаан ертөнцөд эснэсэн хийгээд хаан ширээнд суусан тухай товч өгүүлээд түүний дөрвөн хөвүүний талаар цухас дурдсан байна.

Хоёрдугаар бүлэг: Fasl-i fī bdyān-i dāstān-i Aqsaq Temir /Доголон Төмөрийн домог тайлбарын хэсэг/

Доголон Төмөр хааны төрснөөс насан эцэслэх хүртэлх бүхий л үйл хэргийнх нь талаар голлон өгүүлжээ. Мөн Осман, Булгар зэрэг олон хот, сууриныг эзлэн авсан аян дайны талаар дурджээ. Уг бүлэгт Доголон Төмөр нь ариун Исламын шашныг дэлгэрүүлэгч, Аллахаас гайхамшигт хүч чадлын дэмжлэг авагч, түүний үнэнч анд нөхөр гэсэн өгүүлэмж хэд хэдэн газар тохиолдож байна.

Гуравдугаар бүлэг: Fasl-i fī bdyān-i dāstān-i ‘Īsa oġln Amḡt /Исагийн хүү Амэтийн домог тайлбарын хэсэг/

Иса (Īsa)-гийн хүү Амет(Амḡт)-ийн талаар, түүнчлэн Астраханыг эзэлсэн тухай тодорхой өгүүлжээ.

Дөрөвдүгээр бүлэг: Fasl-i fī bdyān-i dāstān-i Edigḡ Biy /Эдигэ ноёны домог тайлбарын хэсэг/

Ногай (Nogay)-н улсыг үндэслэгч Эдигэ (Edige) ноён, түүний үйл хэргийн талаар өгүүлсэн байна.

Тавдугаар бүлэг: Fasl-i fī bdyān-i mḡjālis wḡ-l mḡkān /Дээд зөвлөл, газар нутгийн тайлбарын хэсэг/

Эдигэ ноёны эзэмшил газар нутаг хийгээд тэдгээрийн эзэгнэгч ноёдын тухай эл бүлэгт тухайлан дурдсан байна.

Зургаадугаар бүлэг: Fasl-i fī bdyān-i dāstānu-t tāriḡ /Домгийн он цагийн тайлбарын хэсэг/

Ижил мөрөн болоод Уралын нуруунаа аж төрөх ард түмнүүдийн түүхийн чухал үйл явдал, хэргүүдийн талаар өгүүлжээ. Тухайлбал, зарим ноёд буруу номтонд дагаар орж өөрийн улсыг тэдэнд эзлүүлсэн тухай тодорхой тэмдэглэсэн байна.

*Dḡftḡr-i Ćingiz-nāmtḡ” сурвалжийн араб үсэг, татар хэлээрх хувилбар эхийн орчуулга, түүний ач холбогдол*

Сурвалжийн зөвхөн энэхүү хувилбар эхийг бид монгол хэлнээ буулгасан бөгөөд нэгдүгээр бүлгийн зарим өгүүлэмжид ажиглалт судалгаа хийхэд нэлээд сонирхолтой баримт мэдээ цөөнгүй тохиолдож байна. Эдгээрийн зөвхөн нэг болох Чингис хаан ноёд түшмэддээ соёрхсон онго шүтээний нэг болох модны талаар авч үзье.

Энэхүү мэдээ “Ddfidr-iĠingiz-nāmd” сурвалжаас гадна өөр сурвалжид ч<sup>51</sup> тохиолдож байгаа талаар судлаач доктор Ц.Төрбат тэмдэглэсэн байна<sup>52</sup>.

Тус сурвалжид, 15 ноён тус бүрт нь нэрлэн олгож байгаа онго шүтээн, тамгуудаас гадна Чингис хааны өөрийнхийг нь оруулаад нийт 16 уриа, мод, шувуу, тамганы нэр, дүрс тэмдэглэгдсэн байна. Тэрхүү моддын нэрсийг жагсааваас: харгай, алимны мод, хар мод, хус, улиангар, хайлаас, далдуу, хадыр, царс, агч, арц, зандан, яшил, нигүрс, чинар. Бидэнд мод тус бүрчлэн тайлбарлахыг зорьсонгүй, харин Чингис хаан ноёддоо эдгээр модыг заан соёрхсон хэмээх өгүүлэмж нь Монгол, Түрэг угсаатантай хэрхэн холбогдохыг тайлбарлахыг хичээсэн юм.

Түрэг угсааны хаадын талаарх ихэнх дурсгалт бичиг, сурвалж, домог туульст дээрхийн адил өгүүлэмж гарах бөгөөд энэхүү түүх бичлэгийн уламжлалаа өөрсдийн шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй холбон тайлбарлах нь бий. Түрэг угсаатны домог туульс дотроос маш сайн судлагдсан гэж үзэж болох Огуз хааны домогт, түүнийг Кцк/тэнгэр/, Таг/уул/, Tengiz/далай/ нэрт хөвгүүдийг нь төрүүлсэн хоёрдугаар эхнэртэйгээ уулзсан талаар “Мөн нэгэн өдөр Огуз хаан анд мордов. Өмнө нь нэгэн нуурын дундах модны холтсон хөмөгт нэгэн охин ганцаараа суух бөлгөө<sup>53</sup>” хэмээн тэмдэглэгджээ. Мөн Ираны алдарт түүхчдийн нэг болох А.Жүвейни-ийн “Tarih-iĠhangъša” буюу “Ертөнцийг эзэгнэгчийн түүх” хэмээх бүтээлд Уйгурын хаан Бөгү-г дөрвөн ахын хамт модноос төрсөн гэх домгийг өгүүлсэн байдаг<sup>54</sup>. Энэ мэтчилэн нийт Түрэг угсаатны дунд ертөнцийн мод /hayatağaz/ хэмээх модон шүтлэг нийтлэг бөгөөд тэдний хамгийн их хүндэтгэн дээдэлдэг мод нь “qaupn” буюу хус мод юм.

Монгол угсаатнуудын дунд ч модон шүтлэг байсан бөгөөд эдүгээ хүртэл уламжлагдан ирсэн байна. Монголын Нууц Товчооны 206-р зүйлд “qutula-qan-nu de[b]segъsaqlār-modun-abawu’asu<sup>55</sup>” гэж буйгаас de[b]segъsaqlār-modun хэмээх хэллэг нь тойрч бүжиглэн, тахин шүтдэг модыг өгүүлсэн бололтой. Эрт үеэс Монголчууд хээр ургасан ганц модыг хүндэтгэн, түүнийг огтолж хугалахыг цээрлэдэг. Энэ нь газар усны эзэд болох лус савдаг тэрхүү ганц модон дээр амардаг гэсэн үзэлтэй холбогдож болох юм.

<sup>51</sup> ШакаримКудайберды-улы, Родословнаятюрков, киргизов, казахов и ханскихдинастий, перевод. Б.Каирбекова, Алма-Ата, 1990.

<sup>52</sup>Ц.Төрбат, Эртниймонгололвгийнбэлгэдэлүүд, -ActaMongolica, Vol.VI(267), УБ., 2006,тал.293-296

<sup>53</sup>ЦзкулЗобаноғлу, ТькДьныasiEpikDestanGeleneği, Ankara, 2003, s. 125

<sup>54</sup>AlaaddinA.M.Cъveyno, Tarih-iĠhangъša, zev. МырселЦзтырк, Ankara, 1988, s. 116-118

<sup>55</sup>Rachewiltzl. De, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, p. 117-118



## Номзүй

1. Б.Азаяа, “Ддфтдр-і Čingiz-nāmd” сурвалжийн судалгаа, -“CORPUS SCRIPTORUM”, Том.V, УБ., 2006
2. Ц.Төрбат, Эртниймонголовгийнбэлгэдэлүүд, -ActaMongolica, Vol.VI(267), УБ., 2006, тал.293-296
3. ШакаримКудайберды-улы, Родословнаятюрков, киргизов, казахов и ханскихдинастий, перевод. Б.Каирбекова, Алма-Ата, 1990.
4. В.П.Юдин, Орды: Белая, Синяя, Серая, Золотая ..., -Казахстан, Средняя и Центральная Азия в XVI—XVIII вв., Алма-Ата, 1983
5. AlaaddinA.M.Съвеуно, Тарих-іCihangъşa, зев. МърселЦзтырк, Ankara, 1988
6. кЕ, ВыеебEdO, МоehgolcooaoaModoa О SidolhEt, FoiB\* Моehgo&oaSoyo&oaakEb;e&oaHoRJI t, 1990, Df& t 4 /Ke. Buyanbatu, Mongyolčud-un modun-u sitylge, Ыыг Mongyol-un soyul-un keblel-ын qoriy-a, 1990/
7. Ддфтдр-іČingiz-nāmd (Das Buch der Dschingis-Legende) I,StudiaUralo-altaica, Maria Ivanics, MirkasymA.Usmanov, Szeged, 2002.
8. ЦзkulЗобаноғлу, ТьркДъныасіEpikDestanGeleneği, Ankara, 2003
9. Rachewiltz I. De, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972
10. Рдхım, G-Гdziz, G. Tatar дддбиyatitarixi, Kazan, 1925
11. Rieu, Ch.Catalog of the Turkish Manuscripts in the British Museum, London, 1888